

Ү, ҮІ ДҮРИЙН ЯЛГУУСАН ХУТАГТЫН УРАГ ТӨРЛИЙН СУДЛАГДААГҮЙ ТҮҮХЭЭС

С.ОТГОНЖАРГАЛ

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд Ү, ҮІ Ялгуусан хутагтууд худ ургийн холбоотой болох тэдний гарал угсаа, амьдралынх нь түүхийг өгүүлэхийг зорилоо. Ү дүрийн Ялгуусан хутагт Лувсанданзанг өргөж авч өсгөсөн эцэг Засагт хан аймгийн Цогтой гүний хошуу ноён Мэргэн ноён Дашдэндэвийн \Дашдондов\намтрыг товчлон анх удаа судлаачдад сонордуулж байна. Мөн онгон судлаачдад контекст болгох зорилгоор ҮІ дүрийн Ялгуусан хутагт Чимэдцэрэнгийн нагац ах болох Гэсэр Жалайр хун тайжийн удмын хүн, гутгаар зэргийн тайж Далай вангийн хошууны Л.Мандал зайсаны онгоны тухай өгүүлэх болно.

Түлхүүр үг: Хутагт, Мэргэн ноён Дашдэндэв, Мандал зайсан, сэтэртэй шар, онгон.

Ү дүрийн Ялгуусан хутагт Лувсанданзан хорвоод хэрхэн мэндэлсэн талаар одоогийн Завхан аймгийн Нөмрөг сумынханы дунд олон янзын домог яриа байдаг. Хутагтын удмын хүн болох Мэргэн ноёны ачинцар өдгөө 82 настай Ж.Балсанжав гуайн ярьсан домгоор “*Хутагтын сүнс төрлөө олох гээд Сартуул ноёны гэрийн тоонон дээр суугаад хартал ноён хатан хоёр эв түнжин муутайхан байхыг хараад тэднийхийг орхин Цогтой вангийн хошуу ноёны гэрийн тооноор нь шагайжээ. Ноён нэгэн лам хүнтэй “мянган” гэдэг тоглоом тоглож, хатан нь бурамтай тараг хутгаад сууж байв. Хутагтын сүнс тэднийд төрөхөөр шийдэж бурамтай тараг руу нь орчихож гэнэ. Бурамтай таргаа хатан уусангүй харин шивэгчин нь уучихаж. Ингэж тэрээр ноёны хатнаас биш шивэгчнээс төржээ.*”¹

Ялгуусан хутагт Лувсанданзан нь Засагт хан аймгийн Цогтой гүний хошууны (одоогийн Завхан аймгийн Нөмрөг сум) засаг ноён Загдсамбарын гуравдугаар хөвгүүн болон мэндэлжээ. Хутагтын эцэг эхээс хайрласан нэр нь Гомбожав. Загдсамбар ноёны хатан, Гомбожав хүүг таалсангүй тул ноёны төрсөн ах Мэргэн

¹ Хувийн архив. Хавтас 8. 2015.12.11. Ж.Балсанжавтай хийсэн ярилцлага.

ноён Дашдэндэв хүүг нярай байхад нь дүүгээсээ үрчлэн авч өсгөжээ. Удаж төдөлгүй Дашдэндэв ноёныд хутагт тодров. Энэ тухай сурвалжид *“Гомбожав хүү олноос онц шинж билиг сайн болоход харьяат чуулганы даргын газраас уламжлан мэдүүлж Их Жургаанаа айлтгаад бумбанд оруулж татан гаргуулж уул сүмийн шавь нарт нийлүүлэн суулгасан хойно харьяат хутагтын хувилгаан Лувсанданзан нэгэнт насанд хүрсний тул хууль ёсоор хувилгаан үсгийг хасуулж жуухыг халж олгуулахыг эрж мэдүүлсэнд Их Жургааны газраас харьяат хутагтын хувилгаан хэмээх үсгийг хасаж жуухыг халж олгуулжээ”*¹ гэжээ.

Мэргэн ноён Дашдэндэв гэж хэн бэ?

Мэргэн ноён Дашдэндэв нь 1848 оны шороон бичин жил Цогтой вангийн хошуу ноён Магсаржавын анхдугаар хөвгүүн болон төржээ. 1862 онд эцэг Магсаржав нь таалал төгсч, Дашдэндэвхүү 14 настайдаа эцгийн орыг залгамжлав. Гэвч удсан ч үгүй Манжийн төрөөс 1864 онд 16 настай Дашдэндэвийг ноёны суудлаас байлгаж хошууны тэргүүн туслагч болгон зэрэг дэвий нь бууруулж таван настай дүү Загдсамбараар эцгийнх нь орыг залгамжлуулсан байна. Загдсамбар нь Магсаржав ноёны дөрөвдүгээр хөвгүүн билээ. Магсаржав ноён Дашдэндэв, Дамдингүржав, Ламжав, Загдсамбар, Жамсранжав гэсэнтаван хүүтэй. Дашдэндэв ноёныг ямар шалтгаанаар ноёны суудлаас буулгасан талаар одоогоор архиваас баримт сэлт олж үзээгүй байна. Монгол Улсын шастирт 1862-1864 онуудад хэн ноён суусан талаар хоосон орхиж 1864 онд Загдсамбарыг тэргүүн зэрэг тайж залгамжлав хэмээн тэмдэглэн үлдээжээ. Монгол улсын шастирт:

*“Наймдугаар удаа залгамжилсан нь Магсаржав, Галдангүнтэвийн хоёрдугаар хөвгүүн. Төр Гэрэлтийн 27 дугаар онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилж, Бүрэн Засагчийн тэргүүн онд \1862 он\ үгүй болжээ. Есдүгээр удаа залгамжилсан нь Загдсамбар, Магсаржавын дөрөвдүгээр хөвгүүн. Бүрэн засагчийн 3 дугаар онд \1864 он\ засаг тэргүүн зэрэг тайж залгамжилжээ”*²

гэсэн байдаг.

Завхан аймгийн Нөмрөг сумын уугуул Б.Бүдээбазар гуай “Түүхэнд Дашдэндэвийн ноён суусан жилийг орхигдуулан Загдсамбар тасралтгүй ноён суусан мэтээр бичигдсээр ирсэн. Магсаржав ноён нас барахдаа Дашдэндэв хүүгээ хошуу ноён болгосон хэмээн нутгийнхан ярьдаг. Гэвч яагаад ч юм хоёр жилийн дараа Загдсамбар Дашдэндэвийн оронд ноён болсон байдаг. Дашдэндэв

¹ Жумдаан, Н. *Очирваань хайрхан соёрхож, Очир хайрханы илгээсэн хутагтууд*. Улаанбаатар: 2007, 26

² *Монгол улсын шастир* -I. Хэвлэлд бэлтгэсэн А.Очир, З.Лонжид, Ц.Төрбат. Улаанбаатар: 1997, 121-122

нэлээд хатуу үгтэй, гоц ухаантай нэгэн байсан гэдэг. Дүү Загдсамбарынхаа Гомбожав нэртэй хүүг нялх байхад нь өөрийн нэр дээр өргөж авсан, хүү таван нас хүрмэгц Ялгуусан хутагтаар тодорч 1885 онд Ялгуусан хутагтын сэнтийд заларсан”¹ гэж хуучилж билээ.

«Монгол улсын Шастир»-аас Цогтой Вангийн хошуу ноёдыг үгүй болмогцтэр жилд нь үр хүүхдүүдээс нь шууд залгамжры нь тодруулж байсныг мэдэж болно. Харин Магсаржав ноёныг нас барсны дараа ноёны суудал 2 жил хоосон байжээ. Завхан аймгийн Нөмрөг сумын уугуул Паадамба лам Мэргэн ноён Дашдэндэвийн тухай “Мэргэн ноён Дашдондов \Дашдэндэв С.О\ ноёны суудалд сууж байхдаа Манжийн алба төлөхгүй гэж зарга үүсгэснээс ноёноос буусан юм. Дээшээ ширүүн доодост зөөлөн, хуулийг чанд баримталдаг хүн байсан. Ямартаа л ноёны суудлаас буусан хэдий ч Дашдэндэвийн Мэргэн цол нь орхигдсонгүй нутаг даяараа түүнийг Мэргэн ноён гэж алдаршуулхав дээ. Ү Ялгуусан хутагтыг нялх байхад нь дүү Загдсамбараасаа өргөж авч өсгөсөн хутагтын эцэгбайхгүй юу”² гэж дурсан ярьжээ. Дашдэндэв ноёны зээ охин В.Амаржаргал “Өвөөг маань хэн хүнгүй Мэргэн ноён гэж хүндэлдэг байсан”³ гэж дурсдаг байв.

Манжийн төрд үнэнч зүтгэсэн болон өргөсөн хандивын хэмжээг харгалзан ноёдуудад хэргэм зэрэг шагнал болгон олгодог байв. “Цогтой вангийн хошууны ноёд ийм тусламж дэмжлэг өгдөггүй байсан болохоор Загдсамбар ноёныг хүртэлх ноёдууд цөмөөрөө цол хэргэмгүй явж иржээ. Үүн дээр Чин улс хотгойдуудыг найдвартай бус гэж үзэж байсан явдал нөлөөлсөн байж болох юм. Галдангүнтэв ноёны үед Засагт хан аймгийн ноёдод пүнлүү олгосон нэгэн жагсаалтаас үзвэл Жанжин Засагтхан 2500 лан, гүн зэрэгтэй засаг ноёд 200 ... авсны дотор тус хошууны засаг ноён Галдангүнтэв 100 лан мөнгөний пүнлүү авч байв”⁴ гэжээ.

Бодит байдал ийм байхад 10 гаруйхан настай Дашдэндэв хүү Манжийн эсрэг үг үсэг гаргасан нь үнэн бол түүнийг ноёны суудлаас буулгаж түүхэнд энэ талаар тэмдэглэлгүй үлдээх эрх нь Манжийн хаанд байсан буйзаа. Ямартаа ч тэргүүн туслагч Дашдэндэв тайжийг нутгийн ардууд Мэргэн ноён, Мэргэн туслагч гэж хоёр янзаар ярьсаар иржээ. Харин 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалд Мэргэн ноён Дашдэндэв нь хүү Лувсанданзангийнхаа хамт идэвхийлэн оролцож хошуунаас цэрэг дайчлан гаргаж цэргийн хэрэглэлд мөнгө үлэмжийг зориулсан учир Богд

¹ Хувийн архив. Хавтас 8. 2015.10.20. Б.Бүдээбазартай хийсэн ярилцлага.

² Хувийн архив. Хавтас 8. 1990.05.06 М.Паадам баламтай хийсэн ярилцлага.

³ Хувийн архив. Хавтас 8. 1983.03.06. В.Амаржаргалтай хийсэн ярилцлага.

⁴ Самданжамц, Ж, Цэрэндорж, Ө, Пүрэвдорж, Г. *Нөмрөг уулын хошууны түүхэн товчоон*. Улаанбаатар: 2013, 43

гэгээнээс түүнд тэргүүн зэрэг тайж хэргэм цолыг эргүүлэн олгосон байна.¹Богд гэгээнийг хаан ширээнд залах төрийн их ёслолд хутагт Лувсанданзан тусгайлан уригдаж Богдод биеэр бараалхан эзэн хаанд мандал өргөн их ёсыг гүйцээсэн байдаг.

Олноо өргөгдсөний хоёрдугаар он буюу 1912 онд Цогтой вангийн чуулганы даргын газраас харъяат Самади багш Лувсанданзанд урьд Чин улсын хаанаас цол, тамга, жуухаар шагнасан зүйлүүдийг тодорхойлон бичиж уламжлуулан хүртээхийг гуйж, Дотоод яамнаа мэдүүлсэнд мөн онд Дотоод яамнаас хутагт Лувсанданзанд цол, тамга, жуухыг хэрэглэх эрхийг олгосны дээр хүрэн жолоог нэмэн шагнагтун хэмээснийг хичээнгүйлэн дагаж шийтгүүлжээ. Ялгуусан Хутагтын тавдугаар дүр Лувсанданзан нь Цогтой вангийн хошуу ноён Магсаржавын Дашдэндэв, Магсаржавын Загдсамбар нарын хүүгийн хувьд хияад боржигон ястай нэгэн байв. Ялгуусан хутагт Лувсанданзан энэ хүндэт цол хэргэмийг 27 жил өргөж явсан бөгөөд 1912 онд жанч халжээ.

Нөмрөгийн уугуул Мэргэн ноён Дашдэндэвтэй худ ургийн холбоотой Б.Бүдээбазар гуай “Ялгуусан хутагт Лувсанданзанг тэнгэрт халихад Дашдэндэв ноён маш их гашуудсан гэж нутгийнхан ярьцгаадаг. Мэргэн ноён Ялгуусан Хутагтындараагийн дүр Чимэдцэрэнтэй их ойр дотно байсан гэдэг. Үүнийг нотлох нэг баримт бол 1950-иад онд Хутагтын эхнэр Хажидмаа\Долгор\ хүү Жасрайсэнгэтэйгээ Нөмрөгт ирж 2 жил амьдарсан. Мэргэн ноёны том охин Зул авхай их холбоотой байж сүйд болж байсныг би сайн мэддэг билээ.Зул авхайн нөхөр тавнан Гомбо бол их баян хүний хүү байсан юм.Зул авхайг нас барахад нь Түдэвтэйн Түшлэг гэдэг газар буюу Дилав хутагтын төрсөн газар нь оршуулсан. Мэргэн ноёны охин гэдэг утгаар нь ард түмэн зөвшөөрч байсан. Харин бүр сүүлд Шагж гэдэг харц хүнийг оршуулахад нутгийн ард ихэд шүүмжилж эсэргүүцэж байжээ. Дилав хутагтын төрсөн газар одоо ч айл буудаггүй их хүндэтгэлтэй газар”²хэмээн ярьж билээ.

Мэргэн ноён хуулиа барихыг шаарддаг зарчимч хүн байв.Ноёдын гэрийн үүдээр ард хүн морьтой өнгөрөхийг хориглосон хууль үйлчилж байсан тухайн үед Дашдэндэв ноёны үүдээр морьтой өнгөрсөн нэгнийг дуудан авчирч хуулийн дагуу банздан шийтгэсэн гэдэг.Энэ тухай Нөмрөгийнхөн одоо ч ам дамжин ярьсаар байна.Энэ болсон үйл явдлаас үзэхэд Дашдэндэв нь ноён байгаагүй бол үүдээр нь морьноосоо буулгүй өнгөрсөн хэн нэгнийг хууль зөрчин банздахгүй байсан

¹ Самданжамц, Ж, Цэрэндорж, Ө, Пүрэвдорж, Г. *Нөмрөг уулын хошууны түүхэн товчоон*. Улаанбаатар: 2013, 56

² Хувийн архив. Хавтас 8. 2015.10.20. Б.Бүдээбазартай хийсэн ярилцлага.

нь лавтай. Нөгөө талаар Дашдэндэв ноёны охидыг өдгөө ч нутгийнхан нь авхай, хүргэчүүдий нь тавнан хэмээн хүндэтгэн ярьдаг. Тухайлбал, Нөмрөгийн уугуул Б.Бүдээбазар гуай, Ө.Цэрэндорж гуайтай уулзан ярилцаж байхад Зул авхай, Гомбо тавнан хэмээн ярьж байсныг бичигч тэмдэглэн авсан юм. Ноёдын охидыг авхай, хүргэчүүдий нь тавнан гэж нэрлэдэг байснаас үзэхэд V Ялгуусан хутагт Лувсанданзанг өргөж авсан эцэг Дашдэндэв нь ноён суудалд сууж байсан гэж үзэх үндэслэл байгаа юм. Мөн Мэргэн цолыг хаанаас хэн, хэзээ олгосныг дараа дараагийн судлаачид нягтлан тодруулах бизээ.

Мэргэн ноён Дашдэндэв нь бага хатан Сарваасэдтэйгээ Нөмрөгийн Баянзүрхээр 1929, 1930 он хүртэл амьдарч байгаад насан өөд болжээ. Мэргэн ноёныг Нөмрөгийн нутаг Адуунчулуун гэдэг газар нутаглуулсан гэдэг ¹.

VI Ялгуусан хутагт Чимэдцэрэн

Сайн ноён хан аймгийн Далай чойнхор вангийн хошууны /одоогийн Архангай аймгийн Цахир сум/ ард Санжжавын 1912 онд нэгэн хөвгүүн мэндэлсэнд Бүдрагчаа хэмээн нэр хайрлажээ. 1915 онд Богд хаан, Бүдрагчаа хүүг Лувсанданзан хутагтын хувилгаан мөн гэж тогтоон түүний нэрийн ард мутарын тэмдэг дарж түүнд Чимэдцэрэн хэмээн номын нэрийг хайрлаж, Ялгуусан хутагтын 6 дугаар үеийн хувилгаанд өргөмжлөв. Чимэдцэрэн хутагтыг Идэрийн Ялгасны хийдэд шавь нарт нь залж суулгах үед Мэргэн ноён Дашдэндэв, Цогтой вангийн хошуу ноён Дамдин-Авшаа нар Лувсанданзан хутагтын хөөрөг, аягыг нь авч очсон гэдэг. Чимэдцэрэн хутагт олон хөөрөг аяга дундаас Лувсанданзан хутагтын эдлэж явсан хөөрөг аягыг төвөггүй таньж “миний юм” гэж хэлж олныг гайхшруулсан аж ². Хүүгийнх нь дараагийн дүр Далай чойнхор вангийн хошуунаас тодорсонд ихэд дурамжхан байсан Мэргэн ноёны сэтгэл ч 3 настай хүүгийн үйлдэлд тайвширчээ.

Чимэдцэрэн хутагтыг Ялгасаны шавьд залагдахад хутагтын ойрын садан төрлийн айлууд бараа болон дагаж ирсэний дотор нутагтаа тэргүүн зэргийн баянд тооцогддог Луузангийн Мандал зайсных байв³. Мандалын аав Луузан Ялгуусан хутагт Чимэдцэрэнгийн ээж Дарь-Раднаагийн /Амаа гэж авгайлдаг байжээ С.О/ нагац ах нь Далай вангийн хошууны Л.Мандал зайсан алтан суурин дээр шигтгэж суулгасан эрдэнийн чулуун жинс, хамба хилэн хүрэм хэрэглэдэг, 3 дугаар зэргийн тайж, Гэсэр Жалайр хун тайжийн удмын хүн юм. Луузан болон хүү

¹ Хувийнархив. Хавтас 8. 2015.10.20. Б.Бүдээбазартай хийсэн ярилцлага.

² Жумдаан, Н. *Очирваань хайрхан соёрхож, Очир хайрханы илгээсэн хутагтууд*. Улаанбаатар: 2007, 39

³ *Ялгасаны шавь Хужиртынхан*. Судлаж эмхэтгэсэн Н.Жумдаан. Улаанбаатар: 2013, 13

Мандал, Мандалын хүү Ванчинхүү нар нь одоогийн Архангай аймгийн Цахир, Завханы Тосонцэнгэл, Их уул, Идэр сумыг хамарсан мал хөрөнгөтэй, адуу малаа энэ нутгийн ард иргэдээр эзэмшүүлэн маллуулдаг нутгийнханыхаа дунд баян чинээлгээрээ зартай хүмүүс байжээ. Л.Мандал нь Ванчинхүү, Артхүү, Өлзийдэлгэр гэсэн гурван хүүтэй хүн юм. Л.Мандал нь Чимэдцэрэн хутагтын нагацын хувьд хутагтын бүхий л асуудлыг шийддэг байв. Хутагтыг Идэрийн Ялгасаны хийдэд залах ёслол, хурим найрын зэрэг ер нь бүхий л зардлыг хариуцдаг байсан тухай нутгийн уугуул Н.Жумдаан гуай “Ялгуусан хутагт Ялгасан гэгээн Чимэдцэрэн” номондоо бичсэн байдаг.

ҮҮИ Ялгуусан хутагтууд худ ургууд болсон нь

Мандал зайсаны ач хүү А.Базаргүрэв, А.Батмөнх нар Мэргэн ноён Дашдэндэв, Мандал зайсан нарын худ ураг болсон түүхийг хуучлахдаа “Нөмрөг, Яруу хоёрын залгаа газар байдаг Чавганцын буудал ньан гөрөө элбэгтэй, хүйтэн булагтай, газар нь намхан сайхан нутаг. Мандал зайсан, Дашдэндэв ноён хоёр энэ газраас болж муудалцсан гэсэн ам яриа байдаг. Үнэндээ бэлчээр газраас болж муудсангүй, Дашдэндэв ноёны шар нь Мандал зайсаны өвсний хашаагийн нь даваад өвсий нь идчихсэнд тэрээрэхэд ундууцсан гэдэг. Тэгээд шарыг төхөөрөөд махнаас нь чанаж байтал нэгэн лам ирээд танайх их л буруу юм хийж байна даа гэж хэлээд махнаас нь ч амсалгүй явчихаж.Тэр шар нь Мэргэн ноёны сэтэртэй шар байсан гэдэг. Үүнээс хойш ажил үйлс нь бүтэлгүйтэх болоход Мандал зайсаны эцэг Луузан, Мэргэн ноён Дашдэндэвтэй хэд хэдэн удаа уулзжээ. Тэд эвлэрэх хэрэгтэй хэмээн тохиролцон ураг барилдах болж Мандал зайсаны хүү Ванчинхүү, Мэргэн ноёны охин Налиндарь нар суусан түүхтэй”¹.

V Ялгуусан хутагт Лувсанданзангийн эцэг Мэргэн ноён Дашдэндэвийн охин, VI Ялгуусан хутагт Чимэдцэрэнгийн нагац Мандал зайсаны хүү нар ураг барилдсанаар хоёр хутагт худ ургийн холбоотой болсон түүхтэй.

Онгоны тухай бодит түүх

Завхан аймгийн Яруу сумын уугуул Н.Жумдаан номондоо “Мандал гуайн эцэг Луузангийнх сайн зүгийн бугтай байсан, тэр нь Мандалын гэргий Лхамсүрэнд үзэгддэг, өөр хүнд үзэгдэдгүй, сөөм хэрийн биетэй, цагаан сахалтай, настай өвгөн дүртэй байжээ. Бурхан тахилдаа өргөсөн идээ ундаа, сархадын дээжийг тэрхүү буг зооголдог, заримдаа согтсон дүртэй харагддаг байж. Тэр бугийг Луузангийн

¹ Хувийн архив. Хавтас 8. 2016.09.09. А.Базаргүрэв, А.Батмөнх нартай хийсэн ярилцлага.

бэр нь \бодвол Лхамсүрэнг хэлсэн болов уу\ галын хайчаар хавчиж аваад галдаа өргөсөн юм гэнэ лээ гэдэг хууч яриа одоо ч Хужиртад яригдсаар байдаг”¹ гэж бичжээ.

Үнэхээр ч Мандал зайсаны мал руу чоно ороход тэрээр “Эрүү нь чилэхгүй бол идэж л байг” гэдэг нэгэн байв. Мандал зайсан баярхсандаа бус харин адуу мал нь хамгаалдаг онгон эзэнтэй болохоор тэрхүү эзэндээ даатгаад орхидог байсан нь тэр аж. Нэг зүйлийг залруулахад тэрхүү онгоныг Мандалын эхнэр нь биш, харин бэр Налиндарь нь айж балмагдсандаагалын хайчаар хавчинбуцалж байсан тогоотой цагаа руу хийсэн гэдэг.²

88 настай Гавьяат хуульч А.Ядмаа /Мэргэн ноёны хоёр дахь охин Чөвдрөнгийн хүү/ Налиндарь эгч ээж хоёр нь түүнийг бага байхад Мандал зайсаны гэрийн онгоны талаар ярьж байсныг сонссоноо дурсан ярьсан юм. “Мэргэн ноёны охин Налиндарь Мандал зайсныд бэр болон очсоноос хойш өглөөд шимийн архи бурхандаа өргөж бай гэсний дагуу шимийн архи хийж тавьдаг байв. Гэтэл хэн нэгэн уучихаад байгаа мэт алга болчихоод байхаар нь ихэд гайхаж нэг удаа ердийнхөөсөө илүү том мөнгөн аяганд шимийн архи хийж тавьжээ. Тавьсан шимийн архи нь ч алга болжсөөм хэрийн биетэй, цагаан сахалтай, согтсон өвгөнгуйваад гараад ирсэнд Налиндарь айж балмагдан түүнийг галын хайчаар хавчинбуцалж байсан тогоотой цагаа руу хийсэн гэдэг. Энэ яриаг сонсож суусан ээж “гал руугаа хийчихгүй дээ” гэхэд “сандраад л тогоо руугаа чулуудсан даа” гэж Няня \Налиндарь\ хэлж билээ” гэж Ядмаа ахыг ярихад нь би ихэд сонирхон “шинжлэх ухаанаас ангид ийм зүйл байдаг юм уу” гэж асуухад тэрээр “би ээж эгч хоёроосоо сонссон зүйлээ л ярьж байна. Тийм юм байсан болоод л Няня маань ярьсан байх. Мандал зайсных сайн зүгийн онгонтой байсан гэж Завханыхан одоо ч ярьдаг юм билээ”³ гэв.

Онгоны талаар МУИС-ийн багш, доктор Д.Бум-Очироос тодруулахад “Онгон гэж бий. Саяхан би Баянхонгор яваад онгонтой айлаар ороод ирлээ. Онгоных нь талаар асуухад гэрийн эзэн “малаа хариулаад явж байгаа” гэж хэлж байсан. Эзэндээ л үзэгддэг “төөхөн чинээ биетэй сахалтай өвгөн байдаг”⁴ гэж дүрслэн хэлж билээ.

Жонатан Свифтийн “Гуливерийн аялал” номны “Гулливер одой хүмүүсийн оронд” хэсэгт сөөмхөн биетэй жижигхэн хүмүүсийн тухай өгүүлдэг. Английн суу билигт зохиолч энэхүү романаа санаанаасаа зохиосонгүй. Үнэхээр эрт цагт одой

¹ Жумдаан, Н. *Ялгуусан хутагтын шавийн хойд аймаг*. Улаанбаатар: 2011, 132

² Хувийнархив. Хавтас 8, 2010.04.21 А.Ядмаатай хийсэн ярилцлага.

³ Хувийнархив. Хавтас 8, 2010.04.21 Гавьяат хуульч А.Ядмаатай хийсэн ярилцлага.

⁴ Хувийнархив. Хавтас 8, 2011.05.06 Д.Бум-Очиртой ярилцсан тэмдэглэлээс.

хүмүүс өөрийн улс гүрнээ байгуулан амьдарч байгаад улс нь мөхөхөд дэлхийн олон орондтархан амьдрах болсон тухай түүхэнд үлджээ. Магадгүй тэдний цөөнхи нь Монголд суурьшин амьдрах болсон гэхэд үгүйсгэх аргагүй юм. Одойчууд нь шударга ёсыг эрхэмлэдэг, үнэнч шударга хөдөлмөрөөр бий болсон эд хөрөнгө, баялгийг хамгаалдаг байжээ. Энэ талаас нь авч үзвэл VI Ялгуусан хутагтын нагац нар болох Луузан, Мандал зайсан, Ванчинхүү нар ньшударга хөдөлмөрөөрөө хөрөнгөжсөн болохоор онгон хэмээн Монголд нэрлэгдэх болсон одойчуудад хүлээн зөвшөөрөгдсөн байна. Шашин шүтлэг хязгааргүй ноёрхож байсан XX зууны эхэн үед сөөмхөн биетэй жижигхэн хүнээс айж цэрвэлгүй харин ч бүр холбоо тогтоож эд хөрөнгөө даатган мануулж байсан нь Тайж Луузан, Мандал зайсан, Ванчинхүү нарын ухааны царын илрэл гэлтэй. Онгоны тухай асуудал өнөөдөр Мета хэвээр байсаар байна.

Abstract: In this article the author aims to tell the blood relations of the 5th and 6thYalguusan Khutugt and to tell about their roots and the true story of their life. The article, for the first time, brings to public attention an abridged and never before published biography of Mergen Noyon Dashdendev (Dashdondov), the Noyon of Tsogtoi gunii khoshuu (banner) of Zasagt khan aimag who adopted and grew the 5thYalguusan KhutugtLuvsandanzan. Also, in order to provide context for researchers, the article tells about a guardian spirit of L.Mandalzaisan of Dalai Wangiinkhoshuu (banner), the descendent of GeserJalairKhuntayiji who is the uncle of the 6thYalguusan KhutugtChimedtseren, the 3rd rank tayiji, and the author tried to correct the misunderstanding which exists among researchers that the noyon's wife threw the gnome into the fire.